ХАСБАНК

Жилийн тайлан 2023

www.xacbank.mn

ТУЗ-ийн даргын мэндчилгээ

Гүйцэтгэх захирлын захидал

Банкны гүйцэтгэл

- Санхүүгийн үзүүлэлтүүд
- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
- Макро эдийн засгийн төлөв
- Банкны салбар
- Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага
- Олон улсын үнэлгээ
- Зээлийн үйл ажиллагаа
  - Иргэдийн зээл
  - Бизнесийн зээл
  - Санхүүгийн түрээс
  - Ногоон санхүүжилт

Эрсдэлийн удирдлага

- Эрсдэлийн удирдлага
- Кибер аюулгүй байдал

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал Нийгмийн хариуцлага

Засаглал

- Гүйцэтгэх удирдлага
- Хөрөнгө оруулагчид
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Төлөөлөл удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, гишүүд
- ТУЗ-ийн үйл ажиллагааны тойм
- ХасБанк ХК-ийн Засаглалын тайлан

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

Татварын дараах цэвэр ашиг

Тэрбум төгрөгөөр



aROE*



Зээл, санхүүгийн түрээсийн багц

Тэрбум төгрөгөөр



Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөгөөр



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ



P/E **4.57**

EPS **138.1** төгрөгөөр

YoY Өмнөх оны мөн үеэй харьцуулсан үзүүлэлт.

* Тайлант хугацааны цэвэр ашигт тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцсон.

ТУЗ-ийн даргын мэндчилгээ

2023 онд ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноор манай банкны хувьд түүхэн онцлох жил болж өнгөрлөө. Нийтдээ 10,000 гаруй иргэн, аж ахуйн нэгж бидэнд итгэл хүлээлгэн Банкны хувьцаа эзэмшигч болсон байна. Ингэснээр бидний хувьд илүү хариуцлагатай, бас шаргуу ажиллах шалтгаан нэгээр нэмэгдэж байна.

Бид 2019 оны эхэн үеэс эхлэн хэрэгжүүлж ирсэн шинэ стратегийн дагуу Банк жилээс жилд амжилтаа улам бүр бататган ажиллаж байна. 2023 он бидний хувьд мөн л түүхэн онцгой амжилт гаргасан жил байлаа. Шинэ стратегиа хэрэгжүүлсэн сүүлийн таван жилийн хугацаанд бид арилжааны банкнуудыг хэмждэг үндсэн үзүүлэлтүүдээ сайжруулж, тус хугацааны татварын дараах цэвэр ашгийн хэмжээгээ жилийн 47 нийлмэл хувиар (CAGR) өсгөлөө.

2023 онд Банкны татварын дараах цэвэр ашиг өмнөх оноос 34.2 хувиар өсөж 142.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь Үнэт цаасны танилцуулгад тусгасан санхүүгийн төсөөллөөс даруй 1 жилээр түрүүлсэн гүйцэтгэл юм. Банкны найдвартай байдлыг илэрхийлдэг түлхүүр үзүүлэлтүүд болох Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа, Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, Активын чанар, Эрсдэлийн сангийн хүрэлцээ үзүүлэлтүүд болон дотоод хяналтын тогтолцоог тогтвортой сайн түвшинд хадгалж чадсан тохиолдолд л тогтвортой ашгийн өсөлтийг бий болгох боломжтой байдаг.

Манай Банкны 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт 20.7 хувь байгаа нь салбартаа шилдэг үзүүлэлтүүдийн нэг юм. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт өндөр байгаагаас үл хамааран өөрийн хөрөнгийн өгөөж (aROE) 26.3 хувь байгаа нь мөн бахархмаар үзүүлэлт юм.

Түүнчлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (liquidity ratio) 37.9 хувьтай байна. 2023 оны эцсийн байдлаар зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа 131.3 хувь, ӨБҮХХ эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа 92.8 хувь, нийлмэл эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа 124.0 хувь тус тус байна.

Бид 2023 оноос эхлэн анх удаагаа хагас жилээр ногдол ашиг хуваарилах бодлогыг хэрэгжүүлж эхлээд байна. Ингэснээрээ Банкны 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилсан ногдол ашгийг ХасБанкны хувьцааг нээлттэй зах зээлээс анх удаа худалдан авсан хөрөнгө оруулагчид хүртэх боломжтой болсон юм.

ХасБанк нь эцсийн өмчлөгч болон хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмших дээд хязгаарыг 20 хувиар тогтоосноороо Монголын банкны салбарт онцгой байр суурь эзэлдэг. ХасБанкийг олон нийтэд нээлттэй хувьцаагаа санал болгохоос өмнө Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (ТСН) 100 хувь эзэмшиж байсан бол, өнөөдөр олон нийт 5.01 хувийг, ТСН 94.99 хувийг эзэмшиж байна.

ХасБанкны Үнэт цаасны танилцуулгад өмнө нь дурдсанчлан, 2024 онд хувьцаа эзэмшигчдийн шийдвэр болон зохицуулагч байгууллагуудын зөвшөөрөлд үндэслэн ТСН ХХК-г ХасБанк ХК-д нэгтгэж, ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийг ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болгох замаар Банкны тухай хуулийн 36.1-г хангахаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд ТСН нь ХасБанкнаас бусад хөрөнгө оруулалтуудаасаа гарч, зөвхөн ХасБанкны хөрөнгө оруулалт болон тодорхой хэмжээний бэлэн мөнгөтэй үлдээд байна.

Өнгөрсөн хугацаанд эдийн засгийн болоод гадаад орчноос үүдэлтэй олон сорилтуудыг даван туулахад хичээнгүйлэн ажилласан Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон түүний удирдлагын баг, нийт ХасБанкны ажилтнууддаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлмээр байна. Мөн тууштай дэмжиж ирсэн ТУЗ-ийн гишүүд болон бүх хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье.

Бид өнгөрсөн таван жилд их зүйлийг хийж, ирээдүйд улам их амжилт гаргах Банкны бат бөх суурийг тавьж чадлаа. Бидний амжилт цаашид ч үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна.

ТУЗ-ийн дарга
САНЖАЙ **ГУПТА**

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг өсгөх стратегийн хэрэгжилт

Өмнөх жилүүдийн нэгэн адил чин сэтгэлээсээ, сэтгэл харамгүй дэмжсэн банкныхаа нийт ажилтан, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Хувьцаа эзэмшигчдэдээ талархал энэхүү захидлаа эхлүүлье. ХасБанк өмнөх жилүүдийн далайц, эрч хүчээ улам нэмэгдүүлж өнгөрсөн онд дэвшүүлсэн стратегийн гол гол санаачилгуудаа амжилттай хэрэгжүүлж, өндөр гүйцэтгэлтэй ажилласныг дуулгахад бахархалтай байна.

> **Бид нийтэд хувьцаагаа маш амжилттай гаргаж, ашигт ажиллагаа, зээлийн багцын зорилтуудаа давуулан биелүүлсэн нь банкны 2023 оны онцлох үйл явдал эргэлзээгүй мөн.**

ХасБанкны өөрийн хөрөнгийн өгөөж 26.3 хувь, активын өгөөж 3.3 хувьд хүрч 142.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай оныг үдлээ (2022 онтой харьцуулбал 34.2 хувиар өссөн). Үнэт цаасны танилцуулгадаа бид 2023 онд 122.8 тэрбум, 2024 онд 141.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай байхаар тусгасан бөгөөд хамтын нөр их хичээл зүтгэл, баг хамт олны харилцан итгэл, ажлын төлөө чин зүтгэлийн үр дүнд банкны ашиг орлогын хэмжээ бидний төсөөлж байснаас даруй бүтэн нэг жилээр түрүүллээ. Иймхүү бид дөрөв дэх жилдээ дараалан цэвэр ашгийн дээд хэмжээг шинэчлэн тогтоосныг энд тэмдэглүүштэй.

Сүүлийн гурван жил дараалан дээд хэмжээгээр тараасан ногдол ашиг, хурдацтай өссөн зээлийн багц, хангалттай хэмжээнд байгуулсан зээлийн эрсдэлийн сан зэргээс үл харгалзан банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр хэвээр байна. Банкны I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 20.7 хувь байсан нь зохицуулагч байгууллагаас тавьж буй шаардлагаас даруй 820 суурь нэгжээр илүү байв.

Эрч хүчтэй санхүүгийн үргэлжлэл

Санхүүгийн гайхалтай үр дүнд хүрэх нь чухал боловч энэхүү амжилтад хэрхэн яаж хүрсэн туршлага мөн адил ач холбогдолтой. Бидний амжилтын гол онцлог бизнесийн бүх чиглэлд амжилттай ажилласанд оршино.

Банкны зорилтот сегментүүд болох иргэдийн банк, байгууллагын банк, лизингийн зээл санхүүгийн түрээсийн багц жилийн турш өссөн бөгөөд нийт зээлийн багц 33.9 хувиар өссөн байна. Харилцагчид, БЖДҮ-ээс бүрдсэн иргэдийн банкны сегмент 37 хувийн гайхалтай өсөлтийг үзүүлсэн бөгөөд үүнд эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон зээл, “Таблет банк”-ны шинэлэг үйлчилгээ голлон нөлөөлсөн. Хэрэглээний зээлийг цахимжуулж, автоматжуулснаар хэрэглээний зээлийн багц өслөө.

> Суудлын тээврийн хэрэгсэл, хүнд даацын тоног төхөөрөмжийн эрэлт нэмэгдсэнээр лизингийн бизнес улам далайцтай болж 2023 онд 54.1 хувиар өссөн.

Зах зээлд шинээр цахилгаан автомашины лизинг, албан ёсны дистрибютор байгууллагуудад банкны нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлж, лизингийн хоёр төвтэй болсон нь шинэлэг байв.

Үйл ажиллагааны ерөнхий орчин сайжирснаар банкны Удирдах зөвлөлөөс тогтоосон эрсдэлийн үзүүлэлтүүдийн хүрээнд байгууллагын банкны багц 13.1 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлт нь эдийн засгийн сэргэлт үргэлжилж, тэлэлт хийгдэж байгааг харуулж байна.

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

ХасБанк хамгийн найдвартай банк болохыг ямагт нотлохоор бид чармайж, хадгаламж эзэмшигчид ч бидэнд итгэл хүлээлгэн үнэнч хэвээр байна. Харилцагчийн харилцах, хадгаламж 17.9 хувиар өссөн нь 2018 оноос хойших хамгийн өндөр өсөлт юм.

Санхүүгийн бусад гол үзүүлэлтүүдийн хувьд бид маш сайн үр дүнд хүрлээ. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт 37.9 хувьд хүрсэн нь дотоодын хадгаламж, гадаад эх үүсвэрийн тэнцвэрийг маш сайн хангаж ажилласны үр дүн байлаа.

Зардал удирдах хатуу сахилга болон хувьсах зардлыг хянах стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр сүүлийн жилүүдэд үйл ажиллагааны хөшүүрэгтэй болсон. Зардал, орлогын харьцаа 40.1 хувьтай байв.

> **Болгоомж бүхий зээлийн бодлого, хатуу хяналт нь чанарт эерэг нөлөө үзүүлсэн. Чанаргүй зээлийн харьцаа 2.9 хувь болсон нь Монгол улсын банкны салбарын хамгийн шилдэг үзүүлэлт юм.**

ХасБанкыг илүү дижитал болгох стратегийн зорилтуудын хүрээнд бид сүүлийн хэдэн жилийн хугацаанд мэдээллийн технологи болон дижитал төслүүдэд ихээхэн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд үр дүнд нь үнэхээр сэтгэл ханамжтай байна. Дижитал хэрэглэгчдийн тоо 31.3 хувь, дижитал гүйлгээ 11.4 хувиар тус тус өссөн. Цаашлаад цахим худалдааны түншүүдтэй хамтран ажилласнаар дижитал зээл болон зээлийн хэмжээ нэмэгдэж байна.

Монгол Улс уур амьсгал, байгаль орчны томоохон сорилтуудтай тулгарсаар байгаа бөгөөд тогтвортой байдлын хөтөлбөрүүд хурдацтай олширсоор байна.

> **ХасБанк Монгол Улсын Засгийн газрын нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах зорилтыг дэмжиж, ногоон санхүүжилтээр банкны салбарыг тэргүүлсээр байна.**

2023 онд банк Парисын хэлэлцээрт шилжих шилжилтийн замын зураглалыг боловсруулж, цаашдын төлөвлөгөө гаргасан.

Шинэ эриний эхлэл: нийтэд хувьцаа гаргах ба банкны шинэчлэл

Бид хамгийн том хоёр IPO-гийн дараа 2023 оны 6 дугаар сарын эхээр олон нийтэд хувьцаагаа амжилттай гаргасан нь өнгөрсөн жилийн түүхэн үйл явдал мөн. Хаан банк, ХХБанкны IPO хөрөнгийн зах зээлээс 300 орчим тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. ХасБанк олон нийтэд хувьцаа гаргасан хамгийн сүүлийн системийн банк байсан нь энэхүү үйл явцыг илүү төвөгтэй болгосныг тэмдэглэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч бид нийтэд хувьцаа гаргах үйл явцыг 117 хувийн захиалга авч дуусгасан бөгөөд 2023 оны сүүл гэхэд 10,000 гаруй хөрөнгө оруулагч ХасБанкны хувьцаа эзэмшигч болсон. ХасБанк (МХБ: ХАС)-анд итгэл хүлээлгэсэн нийт хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа.

Банкны салбарын шинэчлэлийн хүрээнд ТэнГэр Санхүүгийн нэгдэл (ТСН)-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны хувьцаа эзэмшигч болох тул 2024 оны 3 дугаар улиралд ТСН-ийг ХасБанктай нэгтгэх ажлыг дуусгавар болгосноор ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны хувьцааг шууд эзэмших боломжтой болно гэж найдаж байна.

2024 оны хэтийн төлөв

2024 онд макро эдийн засгийн эрсдэлүүд хэвээр байх бөгөөд үүнд дотоодын уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт, дэлхийн зах зээлийн үнэ, геополитикийн асуудлууд нөлөөлсөн хэвээр байна.

2023 оны эцсийн макро эдийн засгийн үзүүлэлтүүд, 2024 оны эхний хоёр сарын нүүрсний экспорт сайн, инфляц нэг оронтой тоогоор хэмжигдэж, валютын нөөц хангалттай хэмжээнд хүрсэн зэргийг үндэслэн үйл ажиллагааны орчны талаарх бидний хэтийн төлөв өөдрөг байгаа.

Эдүгээ COVID-19 тахлын үзүүлэх нөлөөг маш бага хэмжээнд хүргэж бууруулсан, Орос Украины мөргөлдөөнөөс шалтгаалж тогтоосон эдийн засгийн хориг арга хэмжээ нь зохицуулж болохуйц түвшинд байна.

Эх үүсвэрийн бүтэц, цэвэр хүүгийн маржин, зээлийн эрэлтэд хүчтэй нөлөө үзүүлдэг тул бид Монголбанк, АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн бодлогын хүүг анхааралтай ажигладаг. Сүүлийн жилүүдэд актив пассивын удирдлагад оруулсан өөрчлөлтүүдийг эргэн харахад манай банкны тайлан баланс бодлогын хүүнээс үүдэлтэй нөлөөлөлд тэсвэртэй байна гэдэгт итгэлтэй байна.

> **Эцэст нь, бид өөдрөг хандлага, их эрч хүчээ хадгалж 2024 онд өөрийн хөрөнгийн өгөөжийг 20-оос дээш хувь, зээлийн өсөлтийг 20 хувиас давуулж, нийтэд хувьцаа гаргахдаа тооцсон тогтвортой ногдол ашиг тараахыг зорьж байна.**

Дүгнэж хэлэхэд

Амжилт бүрийн ард агуу хамт олон байдаг. Ямагт дэмжлэг үзүүлдэг ТУЗ-ийн дарга Санжай Гупта, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх захирлууд болон Хувьцаа эзэмшигчдэдээ онцгойлон талархлаа илэрхийлье.

Энд мөн би 1,200 гаруй Хасчуудынхаа гайхалтай хүчин чармайлтыг онцолмоор байна. Тэдний ажилдаа туушгай байх ёс зүй мөн сорилтыг даван туулах тэсвэр хатуужилтай байдал нь дэлхийн хэмжээний үйлчилгээг харилцагчдадаа болон олон нийтэд хүргэх ХасБанкны брэндийн амлалтыг бүрэн дүүрэн гайхалтайгаар биелүүлж байна.

Бидний стратеги тодорхой: бид ашигтай өсөлтөө үргэлжлүүлж, ирэх жилүүдэд ч хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн хэвээр байх болно.

Гүйцэтгэх захирал..... Гүмэнжавын **ЦЭВЭГЖАВ**

Банкны гүйцэтгэл

Эрсдлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал/ Нийгмийн хариуцлага

Засаглал

2023 оны санхүүгийн үзүүлэлтүүд

Цэвэр ашиг (татварын дараах)

142.1 тэрбум ₮

2022: 105.8 тэрбум ₮ ▲ +34.2%

Нийт актив

5,119.4 тэрбум ₮

2022: 3,930.8 тэрбум ₮ ▲ +30.2%

Харилцах, хадгаламж

2,850.1 тэрбум ₮

2022: 2,416.4 тэрбум ₮ ▲ +17.9%

Зээлийн санхүүгийн түрээсийн багц

2,749.8 тэрбум ₮

2022: 2,054.1 тэрбум ₮ ▲ +33.9%

Өөрийн хөрөнгө

622.1 тэрбум ₮

2022: 475.7 тэрбум ₮ ▲ +30.8%

Активын өгөөж

3.3%

2022: 3% ▲ +0.3 нэгж хувь

Өөрийн хөрөнгийн өгөөж

26.3%

2022: 24.7% ▲ +1.6 нэгж хувь

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ

20.7%

2022: 20.1% ▲ +0.6 нэгж хувь

Багцад эзлэх чанаргүй зээлийн хувь

2.9%

2022: 4.0% ▼ -1.1% нэгж хувь

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт

37.9%

2022: 41.1% ▼ -3.2 нэгж хувь

Ашигт ажиллагаа

ХасБанк сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагааг сайжруулан ажиллаж байна. Инфляцаас үүдэлтэй мөнгөний хатуу бодлого нь төгрөгийн болон ам.долларын бодлогын хүүгээр дамжин банкны санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, маржинд сөрөг нөлөө үзүүлж байгаа ч ХасБанк орлого олдог активт эзлэх зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлж (багцын өсөлт +33.9%) активын чанарыг сайжруулж чадсанаар 2023 онд банкны нийт цэвэр ашиг 142.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 34.2 хувиар өссөн байна. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 26.3 хувьд хүрч өмнөх оноос +1.6 нэгж хувиар өссөн бол нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг (EPS) 138.1 төгрөг, зах зээлийн үнэлгээ цэвэр ашгийн харьцаа (P/E) 4.57-д хүрсэн байна.





Актив

Банкны нийт активын хэмжээ 5,119.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 30.2% өссөн бөгөөд өсөлтийн ихэнх хэсгийг зээл болон түрээсийн багцын өсөлт бүрдүүлсэн байна. Тайлант хугацаанд багцын чанар сайжирч орлого олдог активын хэмжээ нэмэгдсэнээр банкны активын өгөөж буюу ROA өмнөх оноос 0.3 нэгж хувиар нэмэгдэн 3.3%-т хүрсэн байна.





* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

Зээл, санхүүгийн түрээсийн багц

Зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк, Байгууллагын банк, Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг. 2023 онд Иргэдийн банкны зээлийн багц 37.0 хувиар өсөж 1,921.9 тэрбум, Байгууллагын банкны зээлийн багц 13.1 хувь өсөж 484.9 тэрбум төгрөг, Хаслизингийн багц 54.1 хувиар өсч 342.9 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Иргэдийн банкны зээлийн багц өсөхөд "Таблет Банкинг" үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэсэн бол Хаслизингийн багц нэмэгдэхэд Монгол Улсын гадаад худалдаа, түүний тээврийн асуудал хэвийн горимд шилжиж буйтай зэрэгцээд шинэ машин, механизмын худалдаа сайжирсан нь голлон нөлөөлсөн.





* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

Активын чанар

Нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 33.9 хувь өссөнтэй зэрэгцээд Банк активын чанараа сайн хэвээр хадгалж ажиллалаа. Үүний үр дүнд нийт багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт өмнөх оноос 1.1 нэгж хувиар буурч 2.9 хувьд хүрсэн байна.

Чанаргүй зээлийн үлдэгдэл
Тэрбум төгрөгөөр



Багцад эзлэх чанаргүй зээлийн хувь
%



* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

Харилцах, хадгаламж

ХасБанк нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Харин хадгаламжийн бүтээгдэхүүн энгийн хугацаагүй хадгаламжаас эхлээд хүүгээ сар бүр зарлагадах боломжтой хугацаатай хадгаламж, хүүхдийн урт хугацааны хуримтлалын хөтөлбөрүүдээс бүрддэг. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах цахим сувгийг нэмэгдүүлсний үр дүнд 2023 онд банкны нийт хадгаламж, харилцах 17.9 хувиар өсөж 2,850.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Харилцах, хадгаламжийн үлдэгдэл
Тэрбум төгрөгөөр



Харилцах, хадгаламжийн үлдэгдэл бүтээгдэхүүний төрлөөр
Тэрбум төгрөгөөр



* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

Гадаад эх үүсвэр

Банкны зээл санхүүгийн түрээсийн багцын өсөлтийг хангах, балансын бүтцийг оновчтой удирдах зорилгоор Банкны эх үүсвэрийг гадаад болон дотоод зах зээлээс бүрдүүлдэг. Дотоод эх үүсвэрт харилцагчдаас татсан харилцах, хадгаламжийн эх үүсвэр багтдаг бол гадаад эх үүсвэрт олон улсын банк санхүүгийн байгууллагаас татсан урт хугацаат зээлийн эх үүсвэр багтдаг. 2023 оны байдлаар Банкны гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 330.7 сая ам.доллар байна. Тайлант хугацаанд Банк нийт 205.5 сая ам.долларын урт хугацаат гадаад эх үүсвэрийг IFC, FMO, BlueOrchard, Incofin, Symbiotics, rA, GCF, DWM зээрэг байгууллагуудаас шинээр татсан бол 85.9 сая ам.долларын эргэн төлөлтийг хийж улмаар нийт гадаад эх үүсвэрийн дүн 2023 онд 58.2 хувиар өссөн байна.

Санхүүжүүлэгч түнш байгууллагууд

IFC
FMO Entrepreneurial Development Bank
European Bank for Reconstruction and Development
GREEN CLIMATE FUND
FW DEG
ADB
responsAbility
PROPARCO GROUPE AGENCE FRANÇAISE DE DÉVELOPPEMENT
finnfund
incofin INVESTMENT MANAGEMENT
Developing World Markets
symbiotics
FRONTERA CAPITAL
BlueOrchard Impact Investment Managers
SIFEM SWISS INVESTMENT FUND FOR EMERGING MARKETS
Global Climate PARTNERSHIP FUND managed by responsAbility

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

ХасБанк Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган, хяналт тавин ажиллаж байна. 2019 оноос хойш хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны санхүүгийн үр ашигт байдал сайжирч, эрсдэл даах чадвар тогтвортой нэмэгдэж байна. ХасБанкны хувьд Монголбанкнаас тогтоосон 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээ 12.5 хувь бөгөөд 2023 оны 12 сарын 31-ний байдлаар Банкны 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 20.7 хувь буюу зохицуулагч байгууллагын шаардлагаас 8.2 нэгж хувиар илүү байна. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байх нь аливаа эрсдэлийг даах чадварыг нэмэгдүүлж, мөн ирээдүйд активын өсөлт хийх боломжийг бүрдүүлж байдаг.





Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Арилжааны банкны эрсдэлийн түвшинг илэрхийлэх нэгэн шалгуур үзүүлэлт нь төвлөрлийн харьцаа үзүүлэлт байдаг. 2023 оны 12 сарын 31-ний байдлаар ХасБанкны нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа өөрийн хөрөнгийн 38.6 хувь (Монголбанкнаас 300 хувиас ихгүй байхаар тогтоосон) байсан бол том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа нийт активын 7.8 хувь (Монголбанкнаас 25 хувиас ихгүй байхаар тогтоосон) байгаа нь Банкны үйл ажиллагаа төвлөрлийн эрсдэл багатайг илтгэж байна.

	2020	2021	2022	2023
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа > 12%	17.4%	17.4%	20.1%	20.7%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.8%	-1.1%	6.2%	-1.3%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-4.2%	-2.2%	6.9%	-1.4%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	77.2%	72.8%	66.6%	38.6%
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгийн нийлбэр нийт хөрөнгийн харьцаа <8%	2.5%	1.7%	1.7%	1.3%
Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа <25%	7.0%	7.1%	7.7%	7.8%

	2020	2021	2022	2023
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):				
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.8%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.2%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	1.8%	1.8%	1.6%	3.2%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)				
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.8%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.5%	0.4%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	4.5%	3.8%	3.2%

Олон улсын үнэлгээ

2023 онд тус Банкны үнэлгээний агентлагууд болох Мүүдиз болон Фитч Рейтинг үнэлгээ болон дахин хяналт хийж ХасБанкны гадаад зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээж, баталгаажууллаа. Банк нь тус агентлагуудтай тогтмол харилцаатай байдаг ба макро эдийн засаг банкны секторын мэдээлэл, банкны тухай хууль тогтоомжид гарсан өөрчлөлт, хэрэгжилт болон бусад шаардлагатай тоон мэдээллийг тогтмол цаг алдалгүй хүргүүлж хамтран ажилладаг. ХасБанкны одоогийн зээлжих зэрэглэл нь Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил төвшинд байна

Сүүлийн үеийн явцын мэдээлэл

- **2023 оны 7-р сар:** Fitch Ratings Банкны үнэт цаас гаргагчийн урт хугацааны зээлжих зэрэглэлийг (IDR) ‘B’, бие даан үйл ажиллагаа үргэлжлүүлэх зэрэглэлийг ‘b’, хэтийн төлөвийг тогтвортой хэвээр үлдээж байгааг 2023 оны 7-р сарын 7-ны өдөр зарласан.
- **2023 оны 12-р сар:** Moody’s олон улсын үнэлгээний байгууллагаас 2023 оны 12-р сарын 1-ний өдөр гаргасан тайландаа ХасБанк ХК-ийн зээлжих зэрэглэлийг “B3” хэтийн төлөвийг “тогтвортой” хэвээр үлдээснээ мэдээллэсэн.

MOODY’S

	ХасБанк	Монгол Улс
Зээлжих зэрэглэл - Гадаад валют	B3/NP	B3/NP
Зээлжих зэрэглэл- Төгрөг	B2/NP	B3/NP
Банкны хадгаламж	B3/NP	
Суурь зээлжих зэрэглэл	B3	B3
Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл	B3	B3
Хэтийн төлөв	Тогтвортой	Тогтвортой

FitchRatings

	ХасБанк	Монгол Улс
Урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл	B/Тогтвортой	B/Тогтвортой
Богино хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл	B	B
Урт хугацааны төгрөгийн зээлжих зэрэглэл	B/Тогтвортой	B/Тогтвортой

Зээлийн үйл ажиллагаа

Иргэдийн зээл

Зээлийн багц
1,921.8
2022: 1,402.9 +37.0%

Онлайн багц
445.9
2022: 226.4 +97.0%

+9,000 эмэгтэй бизнес эрхлэгчид
438.8
тэрбум төгрөг

Иргэдийн зээлийн багц 37 хувиар өсөж 1,922 тэрбум төгрөгт хүрлээ. 2023 онд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих барьцаагүй зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, 9,000 гаруй бизнес эрхлэгчид 438.8 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Зээлийн үйл ажиллагаанд харилцагч дээр очиж үйлчлэх үйлчилгээг нэвтрүүлж, зээлийн процессыг ажлын 8 цаг хүртэл богиносгов. Хэрэглээний зээлийг цахим сувгаар авах боломжийг нэмэгдүүлж цалингийн зээл, Амар, Уртаар зэрэг бүтээгдэхүүнийг дижитал банкны сувгаар олгож эхэлсэн. Дижитал сувгаар олгосон хэрэглээний зээлийн багц 47.1 хувьд хүрч өмнөх оноос 97 хувиар өссөн амжилтыг үзүүллээ.

Тайлант хугацаанд Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн үйлдвэрийн яамтай хамтарсан Хүнсний болон Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хүүгийн дэмжлэгтэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Түүнчлэн шатахууны нөөц бүрдүүлэх, ноолуур бэлтгэлд зориулан олгох, махны нөөц бүрдүүлэх, орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж буй ААН-ийн хөнгөлөлттэй зээл олгох зэрэг Засгийн газрын төсөл хөтөлбөрүүдтэй амжилттай хамтран ажиллаж харилцагчдадаа бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олголоо. Засгийн газрын 6 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.



Корпорейт зээл

Харилцагчдынхаа өссөн нэмэгдэж буй санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэж, тэдгээрийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажиллахыг Байгууллагын банкны газар нь ямагт зорин ажилладаг билээ.

Багцын зохистой удирдлага, чанарын түвшин өдөр тутамдаа онцгойлон ажилласны үр дүнд корпорейт зээлийн багцыг өмнөх оноос 13 хувь өсгөж, чанаргүй зээлийн багцын үлдэгдлийг 25 хувиар бууруулав. Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн төсөл хөтөлбөрүүд идэвхийлэн оролцсоны зэрэгцээгээр ногоон эдийн засаг, эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн төслүүдийг түлхүү дэмжин ажилласан онцлогтой жил байлаа. Бид 2023 онд нийт 258.6 тэрбум төгрөгийн бизнесийн зээл олгосноос 80.5 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл, 74.2 тэрбум төгрөгийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон ногоон зээлүүдийг олгосон байна.

Нийгмийн хариуцлага, байгаль орчны бохирдлыг бууруулж ажиллах зорилтын хүрээнд бид 6 дахь жилдээ гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг санхүүжүүлж ажиллав. Өнгөрсөн хугацаанд нийт 58.0 тэрбум төгрөгийн барилгын зээлийн санхүүжилтийг хийсэн бөгөөд тус төслийн хүрээнд 24,464 м.кв газар чөлөөлснөөр шинээр 912 өрх тохилог орон сууцтай болсон бөгөөд жилд хамгийн багадаа 1,311 тонн нүүрсхүчлийн хий бууруулах тооцоолол хийгдээд байна.

ХасБанк нь 2023 онд корреспондент банкны өргөн сүлжээ болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай байгуулсан эх үүсвэргүй баталгааны шугамуудыг идэвхтэй ашигласнаар худалдааны санхүүжилтийн шимтгэлийн орлогыг өмнөх оноос 38.9 хувиар нэмэгдүүлж, 167 тэрбум төгрөгийн аккредитив, баталгаа олгосон нь өмнөх оноос 31.0 хувиар өссөн үзүүлэлт байв.

Бизнесийн зээлийн багц
484.9 13.1%
тэрбум төгрөг

Шинээр олгосон зээл
258.6
тэрбум төгрөг

Аккредитив, баталгаа
167.0 +31.0%
тэрбум төгрөг



ХАСБАНК ТООГООР:

+1,000,000
Харилцагч

+10,000
Хувьцаа эзэмшигч

1,172
Ажилтан

72
Салбар

360
ATM

+7,000
Пос, мерчант

Санхүүгийн түрээс

Санхүүгийн түрээсийн багц

342.9 ▲54.1%
тэрбум төгрөг

Нийт олголт

267.4
тэрбум төгрөг

ХасЛизинг™ нь 2021 оны 11 дүгээр сарыг хүртэл ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн охин компани байсан бол группийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сараас эхлэн компанийн тухай хуулийн 20-р зүйлийн дагуу ХасБанктай нэгдэн, ХасБанкны Лизингийн газар болж үйл ажиллагаагаа явуулж байна.

ХасЛизинг нь Дэлхийд нэр хүнд бүхий автомашин, техник тоног төхөөрөмжийг Монгол Улсад албан ёсоор борлуулдаг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж иргэд, ААН байгууллагад санхүүгийн түрээсээр хурдан шуурхай, нэмэлт барьцаагүйгээр олгодог билээ.

2023 онд Монгол Улсад орж ирэх машин, тоног төхөөрөмжийн импортын татан авалт, тээвэрлэлтийн асуудал хэвийн горимд шилжиж, борлуулалт сайжирснаар нийт 267.4 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийг харилцагчдад олголоо. Ингэснээр санхүүгийн түрээсийн багцын нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 54.1 хувиар өсөж 342.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Монгол Улсад суудлын автомашины борлуулалтаар тэргүүлэгч компаниудтай хамтран ажилладаг бөгөөд 2023 онд ТаванБогд компанийн Тоёота, MSM группын Mercedes Benz худалдааны төвүүдэд өөрсдийн салбар нэгжийг шинэчлэн өргөжүүлж, ХасБанкны бүтээгдэхүүн үйлчилгээг нэг цэгээс шуурхай хүргэж эхэлсэн.

Мөн ХасБанкны автомашины зах зээлд ажиллах стратегийг шинэчлэн боловсруулж, гаалиар орж ирж буй хуучин автомашины зах зээлийн борлуулагч нарт суурилсан аргачлалыг хэрэгжүүлэн, томоохон автомашины цогцолборуудад ХасБанкны автомашины зээлийн 2 төвийг шинээр байгуулж, үйл ажиллагаагаа эхэллээ.

Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий зах зээлд эрэлттэй, түргэн борлогдох чадвартай шинэ хөрөнгийг албан ёсоор нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчдад санхүүгийн түрээсээр олгож байгаа нь багцын чанарыг амжилттай удирдах гол хүчин зүйл юм. Харилцагчдын үйл ажиллагаа явуулж буй бизнесийн салбар бүрд тохируулан санхүүгийн түрээсээр олгосон хөрөнгийн төвлөрлийг оновчтой удирдсанаар, чанаргүй санхүүгийн түрээсийн багцын нийт багцад эзлэх хувийг 1 хувиас бага түвшинд тогтвортой удирдан ажиллаж байна.



Эко Автомашины Лизинг

Нийлүүлэгч байгууллагуудын байгаль орчинд ээлтэй цахилгаан автомашиныг хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр олгож эхлэлээ. Тухайн онд 8.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий бүрэн цахилгаан автомашиныг санхүүжүүлээд байна.

Хуучин автомашин 1 өдөрт

Гаалиар орж ирсэн хуучин автомашиныг 1 ӨДӨРТ багтаан худалдан авахад зориулсан зээлийн үйлчилгээг гарган зах зээлд нэвтрүүллээ.

ХасМоргейж

ХасMortgage төслийн хүрээнд ТОП барилгын төсөл хэрэгжүүлэгч компаниудтай хамтран Амины орон сууц худалдан авах урт хугацааны зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ.

Мада кредит карт

Автомашины хэрэглэгчдэд зориулсан сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ, тоноглол зэргийг санхүүжүүлэх МАДА кредит картыг Автомашины дистрибьютер байгууллагуудтай хамтран хөгжүүллээ.

UBcab хамтын ажиллагаа

Монголын томоохон такси үйлчилгээний систем болох UBcab аппликейшнтэй хамтран такси үйлчилгээнд явж буй бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ.

ХасБанк тогтвортой эрчим хүчний зах зээлд санхүүжилт олгож, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад бодитой хувь нэмэр оруулдаг.

ХасБанк 2009 онд Эко банкны нэгж байгуулан, агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд чиглэсэн ногоон зээлийг олгож эхэлсэн бөгөөд нийт зээлийн багцын 4.31 хувийг ногоон зээл бүрдүүлж байна.

2023 оны байдлаар бууруулсан хүлэмжийн хий

2,543,880 тонн

Ногоон санхүүжилт

Ногоон бизнесийн зээлийн хөтөлбөр

2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2023 оны эцсийн байдлаар нийт 2,202,109 тонн хүлэмжийн хийг бууруулаа. Энэхүү хөтөлбөрийнхөө хүрээнд ХасБанк Монгол Улсад тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх, эрчим хүчний хэмнэлтийг санхүүжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг хэмжилт баталгаажуулалтын чиглэлээр оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ амжилттай хөтлөн явуулахад шаардлагатай санхүү, нягтлан бодох бүртгэл, татварын сургалтуудыг үнэ төлбөргүй зохион байгуулдаг. Банк 2017 оноос хойш 2023 оны эцэс хүртэл эдгээр сургалтуудад нийт 1,246 оролцогчдыг хамруулаа.

Ногоон хэрэглээний зээлийн хөтөлбөр

2019 оноос эхлэн хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2023 оны эцсийн байдлаар 23,851 тонн хүлэмжийн хийг бууруулаа.

Айл өрхийн түвшинд цахилгаан халаагуур, байшингийн дулаалга зэрэг эрчим хүчний хэмнэлттэй технологийн сонголт, хэрэглээг нэмэгдүүлж, хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээс гадна Монгол улсад мөрдөгдөж буй барилгын норм стандарттай харьцуулахад даруй 20 ба түүнээс дээш хувиар бага эрчим хүчийг ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг санхүүжүүлж ажиллалаа.

Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд эрчим хүчийг хэмнэх, гэр байшингаа дулаалахын ач холбогдлыг таниулах, мэдлэг мэдээлэл түгээх зорилгоор сургалт, уулзалтуудыг зохион байгуулж нийт 1422 иргэнийг хамруулаа. Түүнчлэн барилгын компаниудад зориулж байшингийн зураг төслийн шатнаас нь эхлэн эрчим хүчний хэмнэлтийн шаардлагыг хангуулах чиглэлээр чадавхи бэхжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж, сургалтанд хамруулж, байшинг барьж дуусгах хүртэл эрчим хүчний хэмнэлтийн хяналт аудитыг хийж, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зах зээлийг анхнаас нь зөв чиглэлд хөгжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

Мөн ХасБанк нь 2023 онд Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай хамтран өрх, аж ахуйн нэгжүүдэд хүүгийн татаастай хөнгөлөлттэй ногоон зээлийг улс орон даяар олгож, өнөөгийн байгаль орчны тулгамдсан асуудал болох агаар, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн 25 төрлийн технологийг санхүүжүүллээ.

Карбоны санхүүжилт

ХасБанк нь Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд карбон кредитийг НҮБ-ын Цэвэр хөгжлийн механизм болон Карбоны сайн дурын зах зээлд бүртгүүлэн нөхөн олговор хүлээн авах ажлыг ""МикроЭнержи Кредит" байгуулагатай үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Карбоны санхүүжилтийн хүрээнд 2023 онд хийгдсэн онцлох ажил нь Карбоны сайн дурын зах зээлд нийт 399,821 карбон кредитийг амжилттай арилжаалсан явдал байлаа.

Банкны гүйцэтгэл

Эрсдэлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал/ Нийгмийн хариуцлага

Засаглал

Макро эдийн засгийн орчин

Монгол улсын эдийн засаг 2023 онд 7.0%-аар өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбараас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлсэн байна. Тэр дундаа уул уурхай, тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлөв.

Харин өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, эдийн засгийн өсөлтийг хязгаарлав.

Эдийн засгийн өсөлт



Эдийн засгийн өсөлт (7.0%)-д салбаруудын оролцоо

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, (2015 оны суурь үнээр)

Инфляц 2023 оны 12-р сарын байдлаар улсын хэмжээнд 7.9%-д хүрч өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар саарсан байна. Дотоодын голлох хүнсний бүтээгдэхүүний өсөлт өндөр хэвээр байсан нь инфляцад сөргөөр нөлөөлсөн бол импортын барааны үнийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөө өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад буурсан байна.

Хэдийгээр инфляц алгуур буурч байгаа ч ирэх оны төсвийн зардлын тэлэлттэй холбоотой эрэлтийн гаралтай үнийн өсөлтийн дарамт нэмэгдэх эрсдэл байгааг Мөнгөний бодлогын хороо мэдэгдэлдээ дурдсан байна.

Инфляц



Эх сурвалж: Монголбанк

2023 онд нийт экспорт 21%-аар өсч 15.2 тэрбум ам.долларт, нийт импорт 6%-аар өсч 9.2 тэрбум ам.долларт тус тус хүрснээр гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 55%-аар өсөв.

2023 онд манай улсын коксжих нүүрсний гадаад эрэлт нэмэгдэж, улмаар нүүрсний экспорт өмнөх онтой харьцуулахад 37.9 сая тонноор нэмэгдэж түүхэн дээд хэмжээ болох 69.6 сая тоннд хүрсэн нь экспортын орлогын өсөлтөд голлон нөлөөлөв.

Худалдааны тэнцэл
Тэрбум.доллар



Голлох бүтээгдэхүүний экспорт
Сая ам.доллар

Эх сурвалж: Монголбанк

Экспортын орлого нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл оны эцсээр 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Улмаар гадаад валютын албан нөөц (ГВАН) өмнөх оноос 1.5 тэрбум ам.доллараар нэмэгдэж 4.9 тэрбум ам.долларт хүрэв.

Төлбөрийн тэнцэл ийнхүү эерэг байсан нь ам.долларын ханш 2023 оны турш харьцангуй тогтвортой байх суурь нөхцлийг бүрдүүлснээр оны эцэст ам.долларын ханш өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 1%-иар суларсан үзүүлэлттэй байна.

ГВАН болон долларын ханш



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбар

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 12 арилжааны банкны нийт хөрөнгийн хэмжээ 57.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 24.2%-аар өссөн ба системд нөлөө бүхий 5 банк нийт хөрөнгийн 90%-ийг бүрдүүлж байна. Мөн арилжааны банкуудын ашигт ажиллагаа нэмэгдэж системийн хэмжээнд тухайн оны ашиг 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 24.2 хувиар нэмэгдэж 6.2 их наяд төгрөгт хүрэхэд голлох нөлөөг үзүүлсэн байна.

Банкны салбарын иргэд, аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ 2023 онд 23.6%-иар өсч 27.4 их наяд төгрөгт ба энэхүү өсөлтөнд иргэдэд олгосон зээлийн өсөлт голлон нөлөөлсөн байна.

2023 оны 12 дугаар сарын байдлаар төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.7% болж өмнөх жилийн мөн үеэс 1.0 нэгж хувиар өссөн бол, гадаад валютын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 10.5% болж өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн байна. Харин шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 2023 оны эцэст 11.6% болж өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өссөн бол гадаад валютын хадгаламжийн хүү 0.8 нэгж хувиар өсч 4.2%-д хүрчээ.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эцсийн байдлаар банкны салбарын нийт эх үүсвэрийн 69%-ийг харилцах, хадгаламж бүрдүүлсэн байна. Түүнчлэн харилцагчдаас татсан нийт харилцах хадгаламжийн үлдэгдэл тайлант оны эцсээр 34.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 26.3%-аар өссөн байна. Энэхүү өсөлтийн 93%-ийг төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт бүрдүүллээ.

Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нь өмнөх оноос 19.3 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч банкны салбарын нийт зээлийн өсөлтөөс шалтгаалан нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2023 оны эцсийн байдлаар 7.5%-д хүрч өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс гадна анхаарал хандуулах зээл 1.2 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн 4.6%-ийг эзэлж байна.

Эх сурвалж: Монголбанк

Эрсдэлийн удирдлага

Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг үүрэг нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг зохистой түвшинд удирдахын зэрэгцээ бизнесийн нэгжүүдэд стратеги, төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.

Банкны эрсдэлийн удирдлагын аргачлал, чиг үүргийн тодорхойлолт нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд дараах байдлаар суурилсан. Үүнд:

Хамгаалалтын нэгдүгээр бүс	Эрсдэлийг хариуцах эзэн нь байх бөгөөд өөрийн үйл ажиллагааны өдөр тутмын эрсдэлийг удирдана.
Хамгаалалтын хоёрдугаар бүс	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого, журмыг боловсруулж, батлуулж, тэдгээрийн хэрэгжилт, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ, хязгаар үзүүлэлтүүдэд хяналт тавьж ажиллана. Мөн хамгаалалтын нэгдүгээр бүсийн хяналтын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна тэдгээрийн үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж ажиллана.
Хамгаалалтын гуравдугаар бүс	Эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж, хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн эрсдэлийг үр дүнтэй удирдаж буй байдалд хараат бус үнэлэлтийг өгч ажиллана.

Эрсдэлийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тогтоох, эрсдэлийг үр дүнтэй удирдах бодлого, чиглэлийг батлах эрх бүхий этгээд юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн эрх хэмжээний хүрээнд эрсдэлийн удирдлага, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнадаг.

Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо болон Банкны Эрсдэл хариуцсан захирал нь эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэгтэй.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийг удирдах үндсэн зарчим, бодлогын бичиг баримт болох Эрсдэлийн удирдлагын тогтолцооны бичиг баримтыг хянаж, баталдаг. Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцооны бичиг баримтад хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

Эрсдэл даах чадвар	Зохицуулагч байгууллагын тавьсан хязгаарлалтуудын хүрээнд Банкны хүлээж чадах эрсдэлийн хэмжээг хэлнэ.
Хүлээн зөвшөөрөх эрсдэл	Банкны стратеги, бизнес төлөвлөгөөг биелүүлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг хэлнэ.
Эрсдэлийн хязгаар	Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд тогтоосон эрсдэлийн болон багцын хязгаар үзүүлэлтүүдийг хэлнэ

Зээлийн эрсдэлийн удирдлага

Банк нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс үүсэх алдагдлыг зээлийн эрсдэл гэж тодорхойлдог. Зээлийн багц нь Банкны актив хөрөнгийн томоохон хэсгийг бүрдүүлдэг тул зээл, зээлийн эрсдэл нь Банкны удирдах ёстой ач холбогдол бүхий томоохон эрсдэлүүдийн нэг юм. Банк нь зээлийн эрсдэлийн дохиог эрт үед илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авах үүднээс зээлийн хяналтыг тодорхой давтамжтайгаар тогтмол хийдэг ба зээлийн багцын түвшний эрсдэлийг удирдахын тулд зээлийн багцын удирдлагын загвар, хяналтыг хэрэгжүүлснээр Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон зээлийн эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүд болон Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэл нь хүний хүчин зүйл, систем, дотоод үйл ажиллагаа болон гадаад хүчин зүйлээс шалтгаалан бий болдог бөгөөд Банкны бүхий л үйл ажиллагаанд үүсэж болно. Банк нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй, тохирсон хяналтыг хэрэгжүүлж ажилладаг.

Банканд эрсдэлийн соёлыг төлөвшүүлж ажилтнуудыг үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын талаар мэдлэг, мэдээллээр хангах нь эрсдэлийг үр дүнтэй удирдахад чухал ач холбогдолтой. Тиймээс үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж нь 2023 оны турш нийт ажилтнуудад үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог таниулах, мэдлэг, мэдээллийг бататгахад анхаарч ажиллалаа.

Кибер аюулгүй байдал

Гуравдагч байгууллагуудтай холбогдсон холболт дээр кибер аюулгүй байдлын хадлагаас сэргийлсэн сүүлийн үеийн дэвшилтэт систем суурилуулж, хамгаалалтыг улам сайжруулсан.

Кибер аюулгүй байдлын дэвшилтэт технологийг нэвтрүүлэн банкны ажилтнуудын зайнаас хандан ажиллахад кибер аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахад томоохон ахиц дэвшил авчирсан.

Банкны системүүдийн кебир аюулгүй байдлын шалгалтыг сүүлийн үеийн техник, технологи ашиглан илүү чанартай хийдэг болсон.

Банкны сүлжээний дэд бүтэц, сүлжээний аюулгүй байдлыг сайжруулж бэхжүүлэх зорилгоор хандалтыг хянах, холбогдсон төхөөрөмжүүдэд илүү сайн хяналт тавих шийдлийг нэвтрүүлсэн.

Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Банк жил бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооноос хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг Банкны бизнес төлөвлөгөө, стратегитай уялдуулан шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

2023 онд зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг зохицуулагч байгууллагын шаардлага болон Банкны дотоод хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд тогтмол хангаж ажиллалаа.

Банк хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг Монголбанкнаас тавьдаг зохистой харьцааны доод шаардлагыг бүрэн хангаж ажиллахаас гадна хөрвөх чадварын нөөц (liquidity buffer), богино хугацаат хөрвөх чадварын үзүүлэлт (short-term liquidity ratio), хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зэрэг үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд удирдаж ажиллаа.

Хүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Банкны хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий нийт актив пассивын зөрүү болон хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдлын шинжилгээг тогтмол хийж санхүүгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу удирдаж ажилласан.

Тус хугацаанд Банк гадаад валютын позицийн Монголбанкны шаардлагыг бүрэн хангахаас гадна цэвэр нээлттэй позицийн ашиг, алдагдлын хэмжээг (Хамгийн Их Эрсдэл (Value-At-Risk)-ийн үнэлгээ) Банк хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажиллалаа.

Түүнчлэн өнөөгийн эдийн засгийн тодорхой бус байдал давамгайлсан бизнесийн орчинд шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, тохиолдож болзошгүй гэнэтийн хүндрэл нөхцөлүүдэд Банкны санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварт үүсэж болох нөлөөллийг тодорхойлох зорилгоор цочролын тест (стресс тест)–ийн шинжилгээг тогтмол хийж ажиллаж байна.

> Мөн ХасБанк 2023 оноос өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх ICAAP болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх ILAAP аргачлалуудыг олон улсын жишгийн дагуу боловсруулж, туршилтын байдлаар ашиглаж эхлээд байна.

Банкны гүйцэтгэл

Эрсдлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал/ Нийгмийн хариуцлага

Засаглал

Хүний нөөц

ХасБанкны хүний нөөцийн бодлого нь олон талт ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх ажил хэрэгч соёлыг дэмжих, гүйцэтгэлээс хамаарсан өрсөлдөхүйц цалин хөлс, урамшуулал олгох, ажилтнууд үзэл бодлоо нээлттэй, чөлөөтэй илэрхийлэх, шударгаар ажиллах, сурч хөгжих боломжоор хангах, эрүүл, аюулгүй, тав тухтай ажиллах орчныг бүрдүүлэхэд чиглэж ирсэн.

Нийт идэвхтэй ажилтан
1172

Дундаж ажилласан жил
7.9

Шинэ ажилтан
285

Албан тушаал дэвшсэн
136

ХасБанкны ажилтан гэдгээрээ бахардаг:

2023 оны эцсийн байдлаар нийт 1172 идэвхтэй ажилтантай байсан бөгөөд ажилтнуудын дундаж нас 34.9, банканд ажилласан дундаж хугацаа 7.9 жил байна.

Ковидын дараа үүссэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хурд саарч, ажилтнууд ажлын байран дээрээ тогтвортой ажиллах сонирхол нэмэгдсэнээр, ажлаас гарах хувь хэмжээ багасаж, банканд ажилласан дундаж хугацаа нэмэгдэж байна.

Тайлант хугацаанд 285 шинэ ажилтан Хасчуудын эгнээнд нэгдэж, ажил амьдралын гараагаа эхлүүлсэн бол 136 ажилтан банк дотроо албан тушаал дэвшин ажиллаж байна.

Ажилтны оролцоо, сэтгэл ханамж:

Бид ажилтнуудынхаа дуу хоолойг бүхий л түвшинд нээлттэй хүлээн авч, тэдгээрийн нээлттэй оролцоог хангаж ирсэн. Өнгөрч 2023 онд албан тушаалын зэрэглэлээс хамаарсан цалин хөлс, урамшууллын бодлогыг шинэчлэн хэрэгжүүлж, уян хатан ажиллах таатай орчин, нөхцөлийг сайжруулахын зэрэгцээ офиссын засвар үйлчилгээг орчин үеийн түвшинд хийлээ. Ажилтны оролцоо, сэтгэл ханамжийн сүүлийн 3 жилийн судалгааны үр дүн дараалан өсч 88.6 хувьд хүрлээ.

Тогтвортой өндөр гүйцэтгэл:

Бид гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний бодлогыг тууштай баримталж ирсэн. 2023 онд банкны бүтээмжийн үзүүлэлтүүдтэй уялдуулан нийт ажилтнуудын цалин хөлсийг дунджаар 30 орчим хувиар нэмэгдүүлсэн ба бага албан тушаалын ажлын байрны цалин хөлсийг дунджаас илүү хэмжээгээр өсгөж, нийгмийн баталгааг нь хангаж ажиллалаа.

Хүйсийн тэнцвэрт байдал:

Хүйсийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд нийт ажиллах хүчний 67.5 хувь, удирдлагын багийн 51.9 хувийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлж байна.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагын дагуу 2023 оны туршид дунджаар 170 ажилтны ажлын байрыг хүүхэд асрах чөлөөний хугацаанд хадгалсан бөгөөд хүүхэд асрах чөлөөнөөс 81 ажилтан ажилдаа эргэн томилогдлоо.

Ажилтнуудын сайн сайхан оршихуй:

Өнгөрөгч онд ажилтны орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн нөхцөлүүдийг илүү уян хатан болгож сайжруулаа. Ажилтны хөнгөлөлттэй орон сууцны зээл болон Засгийн газрын орон сууцжуулах хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт 120 гаруй ажилтан хамрагдаж, амьдрах нөхцөлөө сайжруулаа.

Ажилтнуудын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах зорилгын хүрээнд ажлын уян хатан цагийн системийг 2018 оноос хэрэгжүүлсэн эхэлсэн бөгөөд 2023 онд ажлын уян хатан цагийн системийг шинэчлэн сайжруулаа.

Түүнчлэн нийт ажилтнуудаа Гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулдаг ба урт хугацааны хуримтлалын хөтөлбөр болох Тэтгэврийн нэрийн дансны хуримтлалын хөтөлбөрт ажилтан бүр хамрагдаж, урт хугацаанд хадгаламж үүсгэх замаар ажилтнуудынхаа санхүүгийн баталгааг хангаж байна.

2023 онд банкны 1,000 гаруй ажилтан дотоодын нэр хүнд бүхий эмнэлгүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, цаашид учирч болох эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлж чадлаа.

Тасралтгүй суралцагч байгууллагын соёл:

Ажилтнуудынхаа ажил, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, тасралтгүй суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг онлайн сургалтын программаар болон танхимын сургалтуудаар дамжуулан хүргэлээ.

Банкны шинэ ажилтнуудыг байгууллагын соёлд сургах, чиглүүлэх зорилгоор сар бүр “Хасжуулах” сургалтыг тогтмол зохион байгуулахаас гадна дотоодын цахим сургалтын платформ (TalentLMS)-аар дамжуулан банкны дотоод сургагч багш нарын бэлтгэсэн 89 төрлийн сургалтын контентуудыг бэлтгэж тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

29,592 Сургатын хүн/цаг

124 Онлайн сургалт

62 Танхимын сургалт

5,796 Ажилтан сургалтанд хамрагдсан

89 Төрлийн сургалтын контент

Тайлант хугацаанд шинээр томилогдон ажиллаж буй Удирдах ажилтнуудыг “Нөхцөл байдалд тулгуурласан манлайлал” сургалтад хамруулахаас гадна, Хувь хүний зан төлөвийн INSIGHT MDI сургалтын дагалдах сургалтад нийт удирдах ажилтнууддаа хамруулаа. Банкны хэмжээнд ажил мэргэжлийн нарийн мэргэшсэн олон улсын сертификаттай ажилтнуудын тоо нийт ажилтнуудын 30 хувьд хүрлээ.

Түүнчлэн салбар, тооцооны төвийн бүхий л албан тушаалын ажилтнуудыг бүтэн жилийн турш мэргэшүүлэх болон борлуулалтын сургалт хөгжлийн хөтөлбөрүүдэд клубийн болон танхимын зохион байгуулалттайгаар хамруулаа.

Нийгмийн болон санхүүгийн боловсрол олгох олон улсын Афлатон хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн 61 сургагч багшийг бэлтгэлээ. Бэлтгэгдсэн сургагч багш нараар дамжуулан 520 хүүхэд, 220 насанд хүрэгчдийг санхүүгийн боловсрол олгох сургалтад хамруулаа.

Багийн амжилт

Бид ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх төрөл бүрийн багийн спортын арга хэмжээг дэмжин ажилладаг бөгөөд 2023 онд манай хамт олон багийн спортын төрөлд үзүүлсэн амжилтуудаа бататган хадгаллаа. Тухайлбал банк хоорондын Гар бөмбөгийн тэмцээнд эмэгтэй алтан медаль, эрэгтэй мөнгөн медаль, Сагсан бөмбөгийн тэмцээний эмэгтэй төрөлд алтан медаль, Талбайн хөлбөмбөгийн эмэгтэй төрөлд алтан медаль, Байт харваа болон Дартсын тэмцээнүүдэд алтан медалийг тус тус хүртсэн.

Банкны гүйцэтгэл

Эрсдлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал/ Нийгмийн хариуцлага

Засаглал

Цахим шилжилт

Төлбөрийн карт

- ББСБ-ууд болон UPI байгууллагатай хамтарсан Кредит карт гаргалаа.
- Platinum метал кредит картыг шинээр гаргав.
- VISA, UPI, ₮ картууд дээр тогтмол хийгддэг сайжруулалтын дагуу шинэ чипийг ашиглаж эхэллээ.
- Шинэ POS төхөөрөмжийг нэвтрүүлсэн.
- Картын төлбөр тооцооны нууцлалыг хангах HSM төхөөрөмжийн шинэчилсэн загварыг нэвтрүүллээ.

Нийт карт эзэмшигч нартаа зориулан ХасБанкны мерчант дээр худалдан авалт тутамдаа 10-20 хувь буцаан олголт авах 8 удаагийн аяныг 70 гаруй мерчанттай хамтарч тогтмол хийж хэрэгжүүллээ.

Мерчант

Бид сүүлийн жилүүдэд мерчантын сүлжээгээ өргөжүүлж, үйлчилгээний чанараа сайжруулахад түлхүү анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд өмнөх онуудтай харьцуулахад мерчант байгууллагын тоог огцом өсгөж 35 хувиар нэмэгдсэний зэрэгцээ гүйлгээний шимтгэлийн орлого 16 хувиар өслөө.

Шинэ бүтээгдэхүүн / автоматжуулалт

Онлайн цалингийн зээл

Цалингийн зээлийг салбарт ирэлгүйгээр дижитал банкаар авах боломжтой боллоо. Цалингийн орлоготой харилцагч бүр ашиглах боломжтой энэхүү шийдлийг нэвтрүүлснээр

- Дараа дараагийн онлайн зээлүүдийг богино хугацаанд бага зардлаар хийх суурь шийдэл, технологийн дэд бүтцийг бий болгов.
- Одоогийн байдлаар нийт олголтын 60 хувь орчим нь цахим сувгаар хийгдэж байна.

Олгосон зээл: **258.8** тэрбум төгрөг

Дижитал банк

Дижитал банкны шинэчлэл, сайжруулалтыг тогтмол хийж, системийн бэлэн байдлыг 100 хувь хангаснаар харилцагчийн тоо 27 хувиар өслөө.

0₮ Шимтгэлгүй банк

Бид 2017 оноос хойш ХасБанкны данс хооронд хийгдэх гүйлгээний шимтгэлийг 0 болгосон ба 2023 онд нийт 1.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн хэмнэлтийг харилцагчдадаа үзүүлсэн байна.

Хэмнэлт: **1.1** тэрбум төгрөг

Тэтгэврийн хуримтлал

Байгууллагуудтай хамтарсан “Тэтгэврийн нэрийн данс”-ны бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

Онлайн зээл

Дижитал банкаар хадгаламж барьцаалсан зээл, онлайн цалингийн зээл, ПОС-н орлого барьцаалсан зээл, Амар зээл зэргийг авах боломжийг бүрдүүлснээр нийт зээлийн багцын 23.2 хувийг онлайн зээл эзэлж байна.

Шинэ систем хөгжүүлэлт

Банкны IPO танилцуулга хийх, захиалга авах зориулалттай веб хуудас болон хувьцаа эзэмшигчдийн хурлын программ шинээр хөгжүүллээ.

Гүйлгээний хяналтын систем

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон гүйлгээний хяналтын цогц AML/KYC системийг амжилттай нэвтрүүлсэн.

Банкны гүйцэтгэл

Эрсдлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал
Нийгмийн хариуцлага

Засаглал

Онцлох үйл явдлууд

ХАСБАНКНЫ IPO ЭНЭ БОЛ ЗӨВХӨН ЭХЛЭЛ

Нээлттэй хувьцаат компани боллоо

2023 оны 6-р сард ХасБанк IPO хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани боллоо. IPO-оор нийт хувьцааныхаа 5.01%-ийг санал болгож 35.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зээл, санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зарцуулж байна.

205.5 сая ам.долларын эх үүсвэр амжилттай татлаа

Бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжихээр Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нидерландын Хөгжлийн Агентлаг, rA, GCPF, БлюОрчард, Симбиотикс, Инкофин, Уур Амьсгалын Ногоон Сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудаас нийт 205.5 сая ам.долларын эх үүсвэр амжилттай татлаа.

ТОП-100 ААН- ийн нэгээр дахин шалгарлаа.

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас зарладаг ТОП-100 ААН-ийн нэгээр дахин шалгарлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал боллоо. Хурлын ирц 95.55 хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр бүрдэж, ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 105,270,000,000 төгрөг болгон нэмэгдүүлэн тогтоох тухай болон ХасБанк ХК-ийн дүрмийг батлах тухай асуудлыг хэлэлцэн батлав.

Ирэх 12-18 сарын хугацаанд ХасБанкны зээлийн чанар тогтвортой байна

Олон улсын үнэлгээний Moody's investors services агентлагаас 2023 оны 12-р сарын 1-ний өдөр гаргасан тайландаа ХасБанк ХК-ийн зээлжих зэрэглэлийн "B3/тогтвортой" үнэлгээг хэвээр үлдээснээ мэдээллээ. Мөн ирэх 12-18 сарын хугацаанд ХасБанкны зээлийн чанар тогтвортой байна хэмээн дүгнэжээ.

Магадлан итгэмжлэлийн эрхээ 2028 он хүртэл буюу 5 жилээр сунгаж шинэчиллээ

ХасБанк НҮБ-ын Уур амьсгалын ногоон сантай "Магадлан итгэмжлэлийн мастер гэрээ" байгуулж магадлан итгэмжлэлийн эрхээ 2028 он хүртэл буюу 5 жилээр сунгаж шинэчиллээ. Мөн ногоон Эрчим хүчний хэмнэлттэй халаагуур, дулаалга болон амины орон сууц санхүүжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 11 сард нэмэлтээр 8 сая ам.долларын эх үүсвэр татан авлаа.

Оюу толгой, МАК, Ази фарма зэрэг томоохон ААН-үүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулав

Оюу толгой, Монголын алт корпораци /МАК/, Ази фарма зэрэг томоохон ААН-үүдтэй Тэтгэвэрийн хуримтлалын сангийн үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ байгуулж, тус компаниудын үндсэн ажилтнууд байгууллагатайгаа хамтран урт хугацааны хуримтлал үүсгэж эхлээд байна.

Нийгмийн хариуцлага

Хасын хүлэгүүд мэргэжлийн сагсан бөмбөгийн багтай 2004 оноос хойш 20 дахь жилдээ хамтран ажиллаж, ивээн тэтгэж байна.

Хасын хүлэгүүд багийн 20 жилийн ойг тохиолдуулан “BANK SHOT” хэмээх хөтөлбөрийг заралсан. Үндэсний дээд лигийн 2023-2024 оны улирлын туршид “Хасын Хүлэгүүд” багийн Bank Shot буюу самбардаж хийсэн бөмбөг бүрд 100,000 төгрөгийг тусгай дансанд хуримтлуулж сан үүсгэх бөгөөд нийт цугларсан мөнгөн дүнг ХасБанкны “Ирээдүйн саятан” хадгаламжтай хүүхдүүдэд сагсан бөмбөгийн спортоор хичээллэх сонирхлыг нь дэмжин, сонирхолтой өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулахад зориулна.

Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан шайбтай хоккейн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа.

Монголын Үндэсний Олимпын Хороо /МҮОХ/-ны 2023-2025 оны “АЛТАН ТҮНШ” байгууллагаар хамтран ажиллаж байна.

Шатрын спортын Их мастер Б.Мөнгөнтуулыг 6-р сарын 4-өөс 11-ний өдрүүдэд Казакстан улсын Алматы хотод болсон 18 дахь удаагийн Азийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд оролцоход дэмжин ажилласан бөгөөд Их мастер Б.Мөнгөнтуул хүрэл медаль авснаар Азийн аваргаас медаль хүртсэн Монголын хоёр дахь эмэгтэй шатарчин болж, Дэлхийн цомын тэмцээнд оролцох эрхээ авсан.

Жил бүр автомашингүй өдрөөр зохион байгуулдаг UB Marathon арга хэмжээг дэмжин хамтран ажиллалаа.

Инээмсэглэл хамтлагийн 45 жилийн ойн концертыг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа.

Хүүхдийн баярыг тохиолдуулан Шатрын их мастер Б.Мөнгөнтуултай хамтран шатрын спорт сонирхогч хүүхэд багачуудын дунд даалгавар биелүүлэх уралдаан зарлаж, 300 орчим хүүхэд идэвхтэй оролцсоноос 30 хүүхдийг шалгаруулан Б.Мөнгөнтуул их мастерын шатрын сургалтын эрхийн бичиг болон Ирээдүйн саятан хадгаламж, Хасхүүгийн гарын бэлгээр урамшуулсан.

НҮБ-ын “Залуу төлөөлөгч – Байгаль орчны манлайлал 2023” хөтөлбөрийг дэмжин, хамтран ажиллалаа. Уг хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, технологи, хууль эрх зүйн салбарын 18-30 насны 30 залууг сонгон шалгаруулж, 2 сарын хугацаанд дэлхийн болон бүс нутгийн, мөн улс орны хэмжээнд тулгарч буй уур амьсгал, байгаль орчны асуудал, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээрх энэ салбарын мэргэжилтний сургалтад хамруулахаас гадна, баг болж бичил төсөл хэрэгжүүлэх боломжоор хангаж буй юм.

Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан Монгол Улсын ууган сургуулийн нэг СЭЗИС-аас зохион байгуулсан “Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол” эсээ бичлэгийн уралдааныг дэмжин хамтран ажиллалаа.

Нийгэм & Санхүүгийн боловсрол олгох ОУ-ын Афлатон хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж 15 төрлийн сургалтын агуулга бүхий Сургагч багшийн гарын авлагыг боловсруулаа. 2023 оны 4 дүгээр улиралд нийт 61 ажилтныг сургагч багшаар бэлтгэн 520 хүүхэд, 220 насанд хүрэгчдийг санхүүгийн боловсролын сургаалтанд хамруулаа.

Бусад

- ЮНЕСКО-ын биет бус соёлын өвд бүртгэгдсэн дэлхийн томоохон хөгжмийн наадмуудын нэг болох Итали улсын Сицил арал дахь Рагуса-Ибла хотод болох олон улсын мэргэжлийн хөгжимчид, зохиолчид, дуучдын уралдаанд МУСТА, төгөлдөр хуурч, төгөлдөр хуурын багш С.Алимааг шавь нарынх нь хамт оролцуулахад дэмжин ажиллалаа.
- 100 буудалт даамын тамирчин Б.Есүйг Куракао улсад зохиогдох 100 буудалт даамын эмэгтэйчүүдийн насан хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон Америк Опен-2023 тэмцээнүүдэд оролцоход дэмжиж ажиллалаа.
- Гольфийн холбооны “Presidents Cup” тэмцээнийг ивээн тэтгэж хамтран ажиллалаа. Бадминтоны 2023 оны Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнийг ивээн тэтгэж хамтран ажиллав.

Банкны гүйцэтгэл

Эрсдлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Цахим шилжилт

Онцлох үйл явдал/ Нийгмийн хариуцлага

Засаглал

Гүйцэтгэх удирдлага

Гүмэнжавын Цэвэгжав
ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдэл Гүйцэтгэх захирал

ХасБанканд: 2011 оноос
Ажлын туршлага: 19 жил

Ганзоригийн Эрдэнэбаяр
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал

ХасБанканд: 2005 оноос
Ажлын туршлага: 18 жил

Энэбишийн Уламбаяр
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал

ХасБанканд: 2013 оноос
Ажлын туршлага: 23 жил

Бавааны Еркин
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал

ХасБанканд: 2002 оноос
Ажлын туршлага: 20 жил

Серикжаны Дауренбек
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал

ХасБанканд: 2000 оноос
Ажлын туршлага: 25 жил

Илия Аврамов
Эрсдэл хариуцсан захирал

ХасБанканд: 2019 оноос
Ажлын туршлага: 25 жил

Ганзоригийн Зул
Үйл ажиллагаа хариуцсан захирал

ХасБанканд: 1999 оноос
Ажлын туршлага: 24 жил

Хүрэлбаатарын Өнөрбат
Мэдээллийн технологи хариуцсан захирал

ХасБанканд: 2012 оноос
Ажлын туршлага: 20 жил

ХасБанканд ажилласан дундаж жил

14

Нямсүрэнгийн Мөнхцэлмэг
Хууль хариуцсан захирал / ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ХасБанканд: 2022 оноос
Ажлын туршлага: 16 жил

Энхбаярын Ундармаа
Ерөнхий Аудитор
/ТУЗ-ийн Аудитын хороонд шууд тайлагнадаг/

ХасБанканд: 2008 оноос
Ажлын туршлага: 25 жил

Хөрөнгө оруулагчид

Үндэсний хэмжээний корпораци, олон улсын томоохон банк, санхүүгийн байгууллага, компаниуд болон иргэд.

Нэг хувьцаа эзэмшигч 20%-аас илүүгүй хувь эзэмших тухай хуулийн шаардлагыг эцсийн өмчлөгчийн хувьд хангаж буй системийн хэмжээний банк.

MAK	19.37%	Invested 2010
IFC	16.63%	Invested 2004
ORIX	16.28%	Invested 2013
European Bank for Reconstruction and Development	12.50%	Invested 2006
NATIONAL BANK	10.18%	Invested 2015
Ronoc	9.83%	Invested 2009
MONGOLIA OPPORTUNITIES PARTNERS	6.42%	Invested 2013
Triodos Bank	3.61%	Invested 2004
Boldoo Magvan	0.10%	
Ganbold Chuluun	0.09%	

5.01%
ОЛОН НИЙТ

10,727	Монгол Улсын иргэн
16	Гадаадын иргэн
31	Хуулийн этгээд
4	Хөрөнгө оруулалтын сан

ХасБанк ХК-ийн 94.99%-г ТСН ХХК, 5.01%-г олон нийт эзэмшдэг бөгөөд ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийг олон нийттэй ижил төвшинд харуулав.

Төлөөлөн удирдах зөвлөл

Санжай Гупта
ТУЗ-ИЙН ДАРГА

ХасБанкны ТУЗ-д: 2017 оноос
Ажлын туршлага: 40 жил

Майкл Мадден
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
РОНОК ПАРТНЕРЗ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2009 оноос
Ажлын туршлага: 30 жил

Н. Цэлмүүн
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
МОНГОЛЫН АЛТ /МАК/ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2012 оноос
Ажлын туршлага: 20 жил

Б. Уламбаяр
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

ХасБанкны ТУЗ-д: 2015 оноос
Ажлын туршлага: 20 жил

Ив Жако
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
КАНАДЫН ИНДЭСНИЙ БАНК төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2016 оноос
Ажлын туршлага: 40 жил

Нираж Вэдва
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

ХасБанкны ТУЗ-д: 2018 оноос
Ажлын туршлага: 30 жил

Анджей Витак
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ЕВРОПЫН СЭРГЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2019 оноос
Ажлын туршлага: 30 жил

Г. Цэвэгжав
ГЗ , ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Компанийн дүрмийн 8.27.д заасны дагуу ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж, байна.

ХасБанкны ТУЗ-д: 2019 оноос
Ажлын туршлага: 19 жил

Албертус Браггинк
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ОРИКС КОРПОРАЦИ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2020 оноос
Ажлын туршлага: 30 жил

Сюзанна Херринг Карр
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2022 оноос
Ажлын туршлага: 30 жил

Эми Чой
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

ХасБанкны ТУЗ-д: 2023 оноос
Ажлын туршлага: 25 жил

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ТУЗ-ийн хараат бус шинэ гишүүн томилогдохоор хүлээгдэж байна.

Сонгон шалгаруулалт явагдаж байна.

Төлөөлөл удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, гишүүд

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

Дарга:
Баянсаны Уламбаяр
(хараат бус)

Гишүүд:
Нираж Вэдва
(хараат бус)

Эми Чой
(хараат бус)

Анджей Витак

Сюзанна Херринг Карр

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй.

Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг саналыг ТУЗ-д танилцуулах үндсэн үүрэг хариуцлагатай.

Дарга:
Ив Жако

Гишүүд:
Албертус Браггинк

Баянсаны Уламбаяр
(хараат бус)

Нираж Вэдва
(хараат бус)

Эми Чой
(хараат бус)

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Уг хороо нь дараах үндсэн үүрэг хариуцлагатай. Үүнд:

1. ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох;
2. Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах;
3. Ажилтнуудын зээлийн нөхцөлийг хянах.

Дарга:
Майкл Мадден

Гишүүд:
Нямтайширын Цэлмүүн

Баянсаны Уламбаяр
(хараат бус)

Нираж Вэдва
(хараат бус)

Эми Чой
(хараат бус)

ТУЗ-ийн үйл ажиллагааны тойм

ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурал

- ТУЗ ийн хурал 13 удаа (ээлжит хурал 5, ээлжит бус хурал 8)
- ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”)-ны хурал 10 удаа
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо (“АХ”)-ны хурал 4 удаа
- Эрсдэлийн удирдлагын хорооны (“ЭУХ”)-ны хурал 4 удаа тус бүр хуралдсан.

ТУЗ нь 9-р сард дараах 2 дотоод журамд өөрчлөлт оруулж, шинэчлэн батлалсан:

1. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам - Компанийн ёс зүйт зан үйлийг бэхжүүлж, хууль тогтоомжид хянан нийцүүлэх зорилгоор, авлига, хээл хахуулийн эсрэг АНУ, Их Британийн хууль тогтоомжийг мөрдөн ажиллах тухай тодорхой заалтыг нэмж тусгах зэргээр Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журамд өөрчлөлт оруулсан.
2. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам - ТУЗ-ийн гишүүн (ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч)-ий бусад Банк, Санхүүгийн нэгдэл болон Банк бус санхүүгийн байгууллага (“ББСБ”)-тай холбогдох хэлхээ холбооноос үүдэн гарч болзошгүй сонирхлын зөрчилд баримтлах тодорхой зарчмуудыг бий болгох зорилгоор ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журамд өөрчлөлт оруулсан.

Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах процесс үргэлжилж байна

ТУЗ нь хагас жилийн ногдол ашиг хуваарилах боломжийг нээх зорилгоор ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай зөвлөмжийг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Хувьцаа эзэмшигчид энэхүү асуудлыг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр эчнээ санал хураан шийдвэрлэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн ХасБанкны ТУЗ-өөс 7-р сард дараах дүрэм, журмуудыг батлалсан болно. Үүнд:

1. ХасБанкны засаглалын кодекс;
2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
3. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дүрэм;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааны журам;
5. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм;
6. Ажилтны зээлийн ерөнхий журам ;
7. ТУЗ-ийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журам;
8. Дотоод аудитын дүрэм;
9. Дотоод аудитын бодлого;
10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
11. Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам;
12. Харилцагчийг таньж мэдэх ерөнхий журам;
13. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам;
14. Шүгэл үлээх бодлого;
15. Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам;
16. Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам;
17. Засаглалын төлөвлөгөө 2023-2026;
18. ХасБанк ХК-ийн дүрэм (улсын бүртгэлд бүртгүүлэх ажил хүлээгдэж байгаа);
19. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам;
20. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам.

ХасБанк ХК-ийн Засаглалын тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

1 Удиртгал
2 Банкны Удирдлага Болон Зохион Байгуулалт
2.1 Хувьцаа Эзэмшигчдийн Хурал
2.2 Хувьцаа Эзэмшигчдийн Бүтэц
2.3 Төлөөлөн Удирдах Зөвлөл
2.3.1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Манлайлал
2.3.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурал
2.3.3 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Бүрэлдэхүүн
2.3.4 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүдийг Сонгох
2.3.5 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үнэлгээ
2.3.6 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүдийн Сургалт
2.3.7 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүдийн Цалин
2.4 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дэргэдэх Хороод
2.4.1 Засаглал, Нэр Дэвшүүлэх, Цалин Урамшууллын Хороо
2.4.2 Эрсдэлийн Удирдлагын Хороо
2.4.3 Аудитын Хороо
3 Гүйцэтгэх Захирал
3.1 Гүйцэтгэх Захирлын Ажлын Гүйцэтгэлийн Үнэлгээ
4 Ёс Зүйн Кодекс, Сонирхлын Зөрчил Ба Толилуулга
5 Сонирхлын Зөрчилтэй Хэлцэл Ба Их Хэмжээний Хэлцэл
6 Дотоод Аудитын Тогтолцоо
7 Ногдол Ашгийн Мэдээлэл
8 Банкны Оролцогч Талуудтай Харилцах Харилцаа
9 Мэдээллийн Ил Тод Байдал

1. Удиртгал

ХасБанкны хувьд 2023 он засаглалын олон үйл явдал өрнөсөн, өөрчлөлт дагуулсан жил байлаа. ХасБанк 2023 онд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбогдуулан өөрийн засаглалын бүтцэд олон шинэ өөрчлөлтийг хийхийн зэрэгцээ ХасБанкны түүхийн салшгүй хэсэг байсаар ирсэн сайн засаглалын зарчмуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

Энэхүү шилжилтийн хугацаанд бид зохицуулалтын шинэ орчинд бүрэн дасан зохицож, оролцогч талуудтай нээлттэй, найрсаг харилцааг бий болгохын тулд жижиг хувьцаа эзэмшигчидтэй харилцах харилцаагаа сайжруулахад анхаарч ажилласан. Бид энэ чиглэлд илүү их амжилтад хүрэх амлалттайгаар энэ оныг дуусгаж байна.

Тайлант хугацаанд, ХасБанк хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсанаас хойших хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит бус хурал 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Блю Скай Зочид Буудал, 3 дугаар давхар, хурлын Даймонд танхимд цахим болон танхим хосолсон хэлбэрээр амжилттай хуралдсан. Хурлын ирц 95.55 хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр бүрдэж, ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болгон нэмэгдүүлэн тогтоох тухай болон ХасБанк ХК-ийн дүрмийг батлах тухай асуудлыг хэлэлцэн баталсан байна.

ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотой өөрчлөлтүүдийг найрсгаар угтан авч, ил тод байдлын өндөр стандартыг үргэлжлүүлэн баримтлахаар хичээнгүйлэн ажиллаж байна.

2. Банкны удирдлага болон зохион байгуулалт

Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь эрх барих дээд байгууллага байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлаар шийдвэр гаргадаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкийг стратегийн удирдлагаар хангадаг. Мөн, Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж танилцуулдаг ба Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулдаг.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон Гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкийг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол тайлагнах үүрэгтэй.

2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны ердийн олонх буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг болон Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал болон нийт гаргасан Хувьцааны 5 хувиас дээш хувийг эргүүлэн авах, ногдол ашиг хуваарилах, өөрийн хөрөнгийн 2 хувиас дээш дүнгээр хөрөнгө оруулах зэрэг Банкны дүрмийн 8.6 дахь хэсэгт заасан стратегийн ач холбогдол бүхий асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулдаг.

2.2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк 2023 оны 2 дугаар улиралд нийт зарласан энгийн хувьцааныхаа 5.01% буюу 52,700,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө татан төвлөрүүлж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болж өөрчлөгдсөн. Ийнхүү ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, нийт зарласан болон гаргасан хувьцааны, 5.01 хувийг олон нийт, үлдсэн хувь буюу 94.99 хувийг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“ТСН”) эзэмшиж байна.

ТСН нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоод болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд болон хувь хүмүүсээс бүрдсэн нийт 10 хувьцаа эзэмшигчидтэй.

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь	#	Хувьцаа эзэмшигч	Хувь
1	**ТСН**	**1,000,000,000**	**94.99%**	1	МАК Инвест Кей Эф Ти	19.37%
				2	Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/	16.63%
				3	ОРИКС Корпораци	16.28%
				4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/	12.50%
				5	Канадын Үндэсний Банк /NBC/	10.18%
				6	Ронок Партнерз Кей Эф Ти	9.83%
				7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	6.42%
				8	Триодос Фэр Шэр Фанд	3.61%
				9	Иргэн Магваны Болдоо /иргэн/	0.10%
				10	Иргэн Чулууны Ганболд /иргэн/	0.09%
2	**Олон нийт**	**52,700,000**	**5.01%**			
Нийт		**1,052,700,000**	**100%**			

2.3. Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны гол хэлбэр нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан явуулах болон эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг зохицуулалттай.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаас бусад хурлуудыг Zoom зэрэг харилцааны холбооны хэрэгслүүдээр дамжуулан зохион байгуулж хуралдуулж байна.
- Ээлжит хурлын чөлөөт цагт, хуваарийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээллийн чанартай онлайн уулзалтуудыг зохион байгуулж Гүйцэтгэх удирдлагаас цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч байна.

2.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн манлайлал

ХасБанк нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн актууд, Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн нийт 22 дүрэм, журам, бодлого болон засаглалын кодексийг шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан.

Шинээр баталсан:

1. ХасБанкны засаглалын кодекс;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааны журам;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журам;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
5. Мэдээллийг ил тод болгох ерөнхий журамд;
6. Харилцагчийг таньж мэдэх ерөнхий журам;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам;
8. Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам;
9. Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам;
10. Засаглалын төлөвлөгөө 2023-2026;
11. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам; мөн
12. Ногдол ашгийн бодлого.

Нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан:

1. ХасБанк ХК-ийн дүрэм;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дүрэм;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм;
5. Ажилтны зээлийн ерөнхий журам;
6. Дотоод аудитын дүрэм;
7. Дотоод аудитын бодлого;
8. Шүгэл үлээх бодлого;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам; мөн
10. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөл нь хагас жилийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах боломжийг нээх зорилгоор ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулан, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулав.

2.3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 удаагийн ээлжит хурлыг оролцуулан нийт 13 удаа хуралдсан бөгөөд нийт 84 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал тус бүрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын өмнөх шийдвэр, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	Ирц (хувиар)
1	Санжай Гупта, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	100%
2	Албертус Браггинк, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	100%
3	Анджей Витак, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	100%
4	Г.Цэвэгжав, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал	100%
5	Ив Жако, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	69%
6	Майкл Мадден, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	100%
7	Нираж Вэдва, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	100%
8	Сюзанна Карр, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	84.6%
9	Б.Уламбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	100%
10	Н.Цэлмүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	92.3%
11	Эми Чой, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	87.5%

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй ээлжит хурлын үеэр нүүр тулсан ганцаарчилсан уулзалтууд хийх болон Гүйцэтгэх захиралтай тохиролцсоноор банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр тодорхой мэдээлэл хүсэх, авах, харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

2.3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Төлөөлөн удирдах зөвлөл нь гишүүн бүрийг асуудлын хэлэлцүүлэгт оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хангах, нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж, түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргахад Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, гишүүдийн тоо, чадвар, мэргэшсэн дадлага туршлага, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус гишүүдийн оролцоог хангах зарчмаар ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны дүрмийн дагуу 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж буйгаас ТУЗ-ийн дарга 1, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох 1 гишүүн, Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 6 гишүүн болон хараат бус гишүүн 3 байна.

Тайлант хугацаанд 1 хараат бус гишүүн үүрэг ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргаснаар хараат бус гишүүний 1 сул орон тоо гарсан. Үүнтэй холбогдуулан 2023 оны 7 дугаар сараас эхлэн нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж нэр дэвшигчдийг бүрдүүлэх ажлыг ХасБанкны Засаглал, нэр дэвшүүлэх,

цалин урамшууллын хороо гүйцэтгэсэн. Улмаар 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшигчдийг танилцуулж, хувьцаа эзэмшигчдээр сонгуулахаар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, аливаа хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд бус гишүүн гүйцэтгэдэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд банкны салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

(2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

№	Нэр	Албан тушаал	Төлөөлөл
1	Санжай Гупта	**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**	-
2	Албертус Браггинк	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ОРИКС
3	Анджей Витак	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ЕСБХБ
4	Гүмэнжавын Цэвэгжав	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал	Дүрэмд заасны дагуу
5	Ив Жако	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Канадын үндэсний банк
6	Майкл Мадден	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Ронок Партнерз Кэй Эф Ти
7	Нираж Вэдва	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Хараат бус
8	Сюзанна Карр	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ОУСК
9	Баянсаны Уламбаяр	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Хараат бус
10	Нямтайширын Цэлмүүн	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	МАК Инвест Кэй Эф Ти
11	Эми Чой	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Хараат бус

2.3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

ХасБанк нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн батлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний залгамж халааны төлөвлөгөөг жил бүр хэлэлцдэг. Уг төлөвлөгөө хэлэлцэх процессыг журамлах зорилгоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний залгамж халааг бэлдэх бодлого”-ыг мөн 2025 оны II дугаар улирал гэхэд боловсруулан баталсан байхаар төлөвлөсөн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуулийн хугацаа дуусах үед гишүүн үүрэгт ажлаа хүлээлгэн өгөх буюу хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. Төлөөлөн удирдах зөвлөлд орон тоо гарах эсхүл Дүрэмд заасан бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр түр томилж болно. Түр томилогдсон гишүүн нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж гаргаж танилцуулах асуудлыг хариуцдаг.

Хуульд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг Банкнаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай мэдэгддэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сонгодог.

2.3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ

Зохистой засаглалын зарчмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өөр хоорондын үнэлгээг тус бүр хийдэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийг бэхжүүлэх, сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломж болохоос гадна үүсгэн байгуулагчид, бусад талуудад өөрийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг.

ХасБанкны Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь 2023 оны 4 сард болсон Төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлын гүйцэтгэл, хурлын ирц, хуралд оролцсон байдал, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн, ажлын гүйцэтгэлийг тийнхүү тайлагнасан.

2.3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сургалт

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг компанийн засаглалын сургалтад нэн тэргүүнд хамруулж Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн засаглалын онцлогийг таниулах сургалтыг зохион байгуулдаг.

Мөн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн анх томилогдмогц түүнд (а) ХасБанкны онцлогийг таньж мэдэхэд зориулсан багц материал, үүнд Өмнөх оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, өмнөх хурлын тэмдэглэл зэрэг бичиг баримтууд, (б) өөрийн үйл ажиллагааг зохистой удирдан явахад зориулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам, ХасБанкны Засаглалын кодекс, ХасБанк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам, Монголбанкнаас баталсан компанийн засаглалын баримт бичгүүд зэрэг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хамаарах бусад бичиг баримтуудыг хүргүүлдэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Гүйцэтгэх захиралтай тохиролцон, Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүй байдлаар Банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж асууж тодруулах, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангагддаг.

2.3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин

болон бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой цалин авдаг ба Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тухайн жилд олгох цалин хөлс нь түүний оролцох шаардлагатай Төлөөлөн удирдах зөвлөл, түүний хороо болон хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэлээс хамааран тодорхойлогдоно. Цалин хөлсийг улирал тутамд олгоно. Зохистой засаглалын зарчмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй байхаар тогтоодог.

Банкинд давхар албан тушаал хашдаггүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хувьцаа эзэмшигчдээс тогтоосон цалин, хороо удирдсантай холбогдуулан олгох нэмэгдлээс өөр бусад шагнал урамшуулал авдаггүй.

2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилготой. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах байнгын хороодтой.

i. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;

ii. Эрсдэлийн удирдлагын хороо; мөн

iii. Аудитын хороо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон Аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж буй гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн Хороодод гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын өмнөх өдөр товлогддог.

2023 онд ХасБанк нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор байнгын Хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, олонхыг хараат бус гишүүдээр бүрдүүлсэн.

2.4.1. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

2.4.1.1 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагаа, чиглэл

Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

Хорооны дүрмийг 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шинэчлэн батлагдсан.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журамтай доорх холбоосоор орж танилцан хорооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авна уу: https://www.xacbank.mn/page/board-committees

2.4.1.2 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн 2023 онд дараах байдалтай байв:

1. Майкл Мадден, дарга
2. Баянсаны Уламбаяр, гишүүн (Хараат бус)
3. Эми Чой, гишүүн (Хараат бус)
4. Нираж Вэдва, гишүүн (Хараат бус)
5. Нямтайширын Цэлмүүн, гишүүн

2.4.1.3 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хурал, ирц

2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо тайлант хугацаанд нийт 11 удаа хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна. Энэ нь хараат бус гишүүний сул орон тоонд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулах ажлыг өргөн хүрээтэйгээр зохион байгуулж, олон шатны ярилцлагуудыг зохион байгуулж ажилласантай холбоотой.

Хорооны хурлын ирц

№	Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүд	Ирц (хувиар)
1	Майкл Мадден, Хорооны дарга	100%
2	Нираж Вэдва, Гишүүн (Хараат бус)	62.5%
3	Баянсаны Уламбаяр, Гишүүн (Хараат бус)	100%
4	Нямтайширын Цэлмүүн, Гишүүн	72.7%
5	Эми Чой, Гишүүн (Хараат бус)	100%

2.4.2. Эрсдэлийн удирдлагын хороо

2.4.2.1 Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа, чиглэл

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журамтай доорх холбоосоор орж танилцан хорооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авна уу: https://www.xacbank.mn/page/board-committees

2.4.2.2 Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

Хороо нь 2023 онд дараах бүрэлдэхүүнтэй ажиллалаа:

1. Ив Жако, дарга
2. Албертус Браггинк, гишүүн
3. Баянсаны Уламбаяр, гишүүн (Хараат бус)
4. Нираж Вэдва, гишүүн (Хараат бус)
5. Эми Чой, гишүүн (Хараат бус)

2.4.2.3 Эрсдэлийн удирдлагын хорооны хурал, ирц

2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал 4 удаа хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

№	Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүд	Ирц (хувиар)
1	Ив Жако, Дарга	50%
2	Албертус Браггинк, Гишүүн	100%
3	Баянсаны Уламбаяр, Гишүүн (Хараат бус)	100%
4	Нираж Вэдва, Гишүүн (Хараат бус)	100%
5	Эми Чой, Гишүүн (Хараат бус)	100%

2.4.3. Аудитын хороо

2.4.3.1 Аудитын хорооны үйл ажиллагаа, чиглэл

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Аудитын хорооны дүрмийг 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар шинэчлэн батлалсан.

Аудитын хорооны үйл ажиллагааны журам, Аудитын бодлоготой доорх холбоосоор орж танилцан хорооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авна уу: https://www.xacbank.mn/page/board-committees

2.4.3.2 Аудитын хорооны бүрэлдэхүүн

Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг.

Аудитын хорооны бүрэлдэхүүн:

1. Баянсаны Уламбаяр, дарга (Хараат бус)
2. Нираж Вэдва, гишүүн (Хараат бус)
3. Эми Чой, гишүүн (Хараат бус)
4. Анджей Витак, гишүүн
5. Сюзанна Херринг Карр, гишүүн

2.4.3.3 Аудитын хорооны хурал, ирц

2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурал 5 удаа хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

№	Аудитын хорооны гишүүдийн ирц	Ирц (хувиар)
1	Б.Уламбаяр, Дарга (Хараат бус)	100%
2	Нираж Вэдва, Гишүүн (Хараат бус)	100%
3	Эми Чой, Гишүүн (Хараат бус)	100%
4	Анджей Витак, Гишүүн	100%
5	Сюзанна Херринг Карр, Гишүүн	100%

3. Гүйцэтгэх захирал

2019 оны 5 сараас эхлэн ХасБанкны Гүйцэтгэх захирлаар Гүмэнжавын Цэвэгжав ажиллаж байна. Гүйцэтгэх захирал нь банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг удирдаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан стратеги, зорилт, бодлогыг хэрэгжүүлж ажиллахаас гадна стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дотоод дүрэм журам, эрдсэл, хяналтын системийг боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр манлайлж ажилладаг.

3.1. Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл болзол, Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн талаар гаргасан Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээ нь түүнд олгох цалин урамшууллыг тодорхойлох үндэслэл болно.

Гүйцэтгэх захирлын 2023 оны ажлын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны гуравдугаар сарын ээлжит хурлаар хэлэлцэж цэвэр ашиг, өөрийн хөрөнгө болон бусад гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт үндэслэн урамшуулал олгосон байна.

4. Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга

ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан, ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилгоор 2023 онд “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна жилд 2 удаа бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй.

ХасБанк нь өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталсан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойш холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их хэмжээний хэлцэл

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 онд нийт 27 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг батламжилсан. Ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримталсан.

Тайлант хугацаанд батлагдсан сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийн жагсаалт

№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)
1	Банкны эрх бүхий албан тушаалтан	244,179,750
2	Банкны эрх бүхий албан тушаалтан	50,000,000
3	Банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан	147,000,000
4	Банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан	1,200,000
5	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
6	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	3,600,000

№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)
7	Банкны нэгдлийн оролцогчийн холбогдох этгээд	50,000,000
8	Банкны нэгдлийн оролцогчийн холбогдох этгээд	50,000,000
9	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалттай компани	7,000,000,000
10	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	100,000,000
11	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
12	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	608,646.96
13	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	429,084.02
14	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	655,112.16
15	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	591,127.27
16	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалттай компанийн эрх бүхий албан тушаалтан	5,000,000
17	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалттай компанийн эрх бүхий албан тушаалтан	3,000,000
18	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	90,000,000
19	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
20	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000
21	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	500,000
22	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
23	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000
24	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	500,000
25	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	100,000,000
26	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	180,000,000
27	Банкны эрх бүхий албан тушаалтан	417,300,000

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.

6. Дотоод аудитын тогтолцоо

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэл тайлбар өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.
Төлөөлөн удирдах зөвлөл нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2023 онд хөндлөнгийн аудитороор Эрнст Янг компани аудит хийж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяа Аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд улирал бүр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг.

- Санхүүгийн тайлан, санхүүгийн үзүүлэлтүүдийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд болон эрх зүйн бусад актуудтай нийцэж байгаа эсэхийг хянах;
- Банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, үнэлэлт, дүгнэлт өгөх, Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, гол эрсдэлүүд, түүнийг хэрхэн удирдаж буй талаар чиглэл өгөх;
- Дотоод аудитын хараат бус байдлыг хангах, төсвийг батлах, удирдах, гүйцэтгэлийг хянах, дотоод аудитын тайланг хэлэлцэх, Аудит хариуцсан захирлыг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах, цалин, урамшууллыг тогтоох; мөн
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, чөлөөлөх, гүйцэтгэлийг үнэлж холбогдох саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх.

Дотоод аудит нь банкны дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг үнэлж, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг аудитлуулагч талд бэлтгэн хүргүүлж, тухайн зөвлөмжийн мөрөөр хийгдсэн ажилд хяналт тавьж, үр дүнг нь тайлагнах байдлаар банкны үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулдаг.

Дотоод аудитын газар нь Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны гурав дах хамгаалалтын шугам болж ажилладаг бөгөөд Дотоод аудиторуудын хүрээлэнгээс гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, ёс зүйн дүрмийг дагаж мөрддөг.

7. Ногдол ашгийн мэдээлэл

ХасБанк нь олон нийтэд хувьцаа гаргахаас өмнө буюу 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 2022 оны санхүүгийн жилийн цэвэр ашгаас 30 тэрбум төгрөгийн ногдол ашгийг ХасБанкны хувьцаа эзэмшигчдэд хуваарилах шийдвэрийг гаргаж хуваарилсан.

Үүний дараа, ХасБанкны 2023 оны эхний хагас жилийн ногдол ашгаас 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг зарлаж, хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлэн 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн нэрийн дансанд байршуулан тарааж дууссан байна.

Ийнхүү цаашид хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах боломжийг нээх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл мөн дээрх хурлаар ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлууллаа.

8. Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа

ХасБанк нь хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар болон цахим шуудангаар харилцах харилцааг үнэн зөв, ижил жигд, хууль тогтоомжид нийцсэн байдлаар удирдан зохион байгуулах зорилгоор “Хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журам”-ыг 2023 оны 11 сарын 30-ны өдөр шинээр баталсан.

ХасБанк нь өөрийн xacbank.mn цахим хуудсаар дамжуулан оролцогч талуудад мэдээллийг тогтмол хүргэж, түүний санал, гомдол хэсгээр дамжуулан оролцогч талуудтай харилцан ажиллаж байна.

9. Мэдээллийн ил тод байдал

ХасБанк нь өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод тайлагнан, мэдээлэх зорилгоор “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж буй бөгөөд, Төлөөлөн удирдах зөвлөл нь түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.